# САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Л.ХАШ-ЭРДЭНИЙ 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС (УДИРДАХ АЛБАН ТУШААЛТАН БУЮУ НЭГЖИЙН ДАРГА)

Байгууллагын нэр: Аймгийн Засаг даргын Тамгын газар
Нэгжийн нэр: Санхүү, төрийн сангийн хэлтэс

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | 97.3 | 68.1 |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Хариуцсан ажлын хүрээнд сургалтад хамрагдах | | 6 |
| 2. | Хариуцсан салбарын байгууллагыг мэргэжил, арга зүйгээр хангаж ажлын байрандаа суралцах | | 7 |
| 3. | ………………….. | | |
| | **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | 13. |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 14 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 14 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 14 |
| 4. | Манлайлах | 14 |
| 5. | Багаар ажиллах | 14 |
| 6. | Харилцаа | 14 |
| | Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | |
| | **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | 14 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | 68.1 |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 13. |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | 14 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | ….. оноо |
| | **Нийт оноо =** | 95.1 |

| | |
|---|---|
| ( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ................................ /Ш.ЭРДЭНЭБАТ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.09 ................................ *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ................................ /Л.ХАШ-ЭРДЭНЭ/
*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.03 ................................ *(огноо)*

# САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.12.25

Алтай хот

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэт-гэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | | |
| **Зорилт 1. Төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх /Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 5.3, Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1 /** | | | | | | | | |
| 1.1 | Төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах бүхэл үе шатанд иргэдэд нээлттэй байж, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулна. | - | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь | 97 | 98 | 98 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2022 онд 96.97 хувь, 2023 онд 95.24 хувь, 2024 онд 95.31 хувь, 2025 оны 10 сарын байдлаар 96.77 хувьтай байна.<br>2025 оны 10 сарын байдлаар хуулийг хангалтгүй хэрэгжүүлсэн нийт 17 төсөвт байгууллага, сан, нэгдсэн системийн мэдээлэл байршуулах үүрэг бүхий албан тушаалтнуудад зөрчлийг арилгах тухай албан бичгийг хүргүүлэн ажиллаж байна. | 90 |
| 1.2 | Татварын бааз суурийг өргөжүүлэн, хамрагдалтын түвшинг нэмэгдүүлэх, уул уурхайн компаниудаас орон нутгийг төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлнэ. | - | Татварт хамрагдалтын хувь | 75 | 77 | 77 | Хууль тогтоомж мөрдөлтийн стратегийн хэрэгжилтийн талаар:<br>-Татварын хууль тогтоомж даган мөрдөлтийн 3,4-р түвшний урьд оны өртэй 35280 татвар төлөгчийн 4441411.8 мянган төгрөгийн өрнөөс шат дараалсан арга хэмжээг хэрэгжүүлэн 7176 татвар төлөгчийн 1053750,6 мянган төгрөгийг , тайлант оны 49962 татвар төлөгчийн 3676388,3 мянган төгрөгийн ногдолоос 16049 татвар төлөгчийн 1893139,7 мянган төгрөгийг тус тус барагдуулсан.<br>-Татварын өр төлбөрөө хувиарын дагуу төлөх амлалтыг 18 татвар төлөгчөөс гаргуулан авч, төлөлтийг сар сард шахаж барагдуулан ажиллаж байна.<br>-ТЕХуулийн 53 дугаар зүйлд заасан “Өр | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөх хугацааны хөнгөлөлт"-ийг нэг татвар төлөгчид газрын даргын тушаалаар эдлүүлсэн.<br>-Их хэмжээний өртэй татвараа хугацаандаа төлөөгүй, ХТМТ-3.4-р түвшний өртэй 7 татвар төлөгчийн хөрөнгийн байдлыг тогтоосон боловч битүүмжлэх хөрөнгөгүй учир шүүхэд нэхэмжлэл гаргахаар бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байна.<br>-Татвар төлөгчийн хүсэлтийн дагуу нэг татвар төлөгчийн авлага битүүмжлэх ажиллагаа хийгдсэн.<br>-Хаяг байршилдаа байхгүй 2 татвар төлөгчийг эрэн сурвалжилахаар шүүхэд хүсэлт гаргасан.<br>-Татварын өрийн үлдэгдэлтэй нас барсан 68 иргэнийг шүүхэд нэхэмжлэл гарган 2025.09.26-ны өдрийн байдлаар 48 иргэний татварын 14095.1 мян.төг-ний өрийг хүчингүй болгох шүүхийн шийдвэр гаргуулсан.<br>Хувь хүний орлогын албан татварын талаар:<br>2024 оны жилийн эцсийн ХХОАТ-ийн ТТ-06 тайлангаар 5221 иргэний 482989,5 мянган төгрөгийн ногдолтой, ХГ-ээр 2066 иргэний 213249,3 төгрөгийн ногдолтой, нийт 7305 иргэний 696406,8 төгрөгийн ногдолтой тайланг тус тус хүлээн авч ажилласан.<br>Нийт 837 татвар төлөгчийн 329762.5 төгрөгийн өрийг төсөвт төвлөрүүлсэн<br>Үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн талаар:<br>-Улсын бүртгэлийн газрын мэдээлэлд үндэслэн 79 шинэ татвар төлөгчийг үл хөдлөх хөрөнгийн албан татвар төлөгчөөр шинээр бүртгэж, Т дугаартай 27 үл хөдлөх хөрөнгийг Ү дугаартай болгон бүртгэлийн мэдээллийг шинэчилж, борлуулсан болон | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шилжүүлсэн 12 хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэлд шинэчилж, шинээр 104 хөрөнгөнд албан татвар ногдуулж, холбогдох бүртгэлийг хийсэн. Жижиг, бичил сегментэд харьяалагдах 374 үл хөдлөх хөрөнгийн албан татварын ногдлыг амжилттай үүсгэн ажиллалаа.<br>АТБӨЯХ-ийн бүртгэлийн талаар:<br>Газрын даргын баталсан удирдамжын дагуу АТБӨЯХАТ-ийн урьд оны өр , тайлант оны ногдолыг барагдуулах ажлыг зохион байгуулан бүх сумдын засаг дарга болон багийн дарга нарт газрын даргын хамтран ажиллах албан бичгийг хүргүүлсэн.<br>2025 оны 06 сарын 07-ны өдрийн байдлаар АТБАЯХАТ-ийн урьд оны өртэй 6495 татвар төлөгчийн 765728.8 мянган төгрөгөөс 1252 татвар төлөгчийн 81484,6 мянган төгрөг, тайлант оны 8715 татвар төлөгчийн 468726,7 мянган төгрөгийн ногдолоос 5802 татвар төлөгчийн 248196.3 мянган төгрөгийг тус тус барагдуулан ажилласан.<br>Шинээр бүртгэгдсэн 78 тээврийн хэрэгслийн мэдээллийг шинэчилсэн, эзэмшигч шилжсэн 281 тээврийн хэрэгсэл бүртгэлийг шинэчилсэн, 466 тээврийн хэрэгслийг аймгийн авто тээврийн төвийн бүртгэл, лавлагааг үндэслэн хасч ажиллалаа. ТЕГ-ын даргын чиглэлийн хүрээнд 2052 татвар төлөгчийн АТБӨЯХ-ийн албан татвар төлөгчийн нөхөн ногдуулалтыг хийж гүйцэтгэлээ. Галт зэвсгийн бүртгэлийн талаар:<br>Цагдаагийн байгууллагаас ирүүлсэн 2024 оны 2319 Галт зэвсгийн эзэмшигчдийн судалгааны дагуу ТУНС-ын хөрөнгийн жагсаалтаар бүртгэлтэй 2215 галт зэвсгийг сумдын ТУБ нарт үүрэг чиглэл өгч, сум тус | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | бүрээр тулгалтыг хийн 17 сумын цагдаагийн галт зэвсгийн сангийн бүртгэл, ТУНС-ын хөрөнгийн бүртгэлийг тулгах ажлыг хийн давхардсан болон бүртгэл буруу 163 галт зэвсэгийг хассан, 72 галт зэвсэгийг шинээр бүртгэн, ТУНС-д эзэмшигч шилжсэн 79 иргэний хөрөнгийг шилжүүлэх ажлыг хийсэн. Галт зэвсгийн тулгалтыг хийхэд аймгийн хэмжээнд хийт 112 иргэний галт зэвсгийн татварын албанд бүртгэлгүй байгаа боловч бүртгэх боломжгүй тухайн иргэн нас барсан болон бүртгэх байгууллага регистрийн дугаарыг буруу бүртгэсэн байгааг засварлан бүргүүлэх албан бичгийг аймгийн цагдаагийн газарт 2 удаагийн албан бичиг хүргүүлж, хамтарч ажилласан. Галт зэвсэг байхгүй болон эзэмшигч нас барсан 11 иргэний өргөдөлийг хүлээн авч цагдаагийн галт зэвсэг хариуцсан а/д Ч.Ачитбаатарт хүлээлгэн өгсөн.<br>Аймгийн Прокорурын газартай хамтран ажиллах албан бичиг болон зөрчилтэй 102 галт зэвсгийн судалгааг хүргүүлсэн.<br>Газрын бүртгэлийн талаар:<br>Газрын албанаас ирүүлсэн цуцлагдсан 986 нэхэмжлэхийн жагсаалтыг ТУНС-д тулгасан. Дэд алба буруу үүссэн 584 нэхэмжлэхийг ТЕГазрын Бүртгэлийн хэлтэст уламжлан засварлуулсан.<br>Татварт хамрагдалтын түвшинг 2025.11.10-ны өдрийн урьдчилсан байдлаар тооцвол:<br>ААНОАТ 956-728 76.2%<br>ОАТ 2-2 100%<br>НӨАТ 190- 134 70.5%<br>ЦА 561-532 94.8%<br>Үйл.аж ОАТ 5229 -3143 60.1%<br>ҮХЭХАТ 953-510 55.7%<br>АТБӨЯХАТ 16853-10410 63.8% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ГЗАТ 1912-1274 69.6%<br>Суутгагч 33-33 100%<br>Газар 8321-5210 62.6%<br>Ус бох.төлбөр 1-1 100%<br>Нүүрс АБТ 2-2 100%<br>Дундаж хувь: 78,1% | |
| 1.3 | Төрийн сангийн дотоод хяналтын үр нөлөөг дээшлүүлж, эрсдэлийг бага түвшинд хүргэнэ. | - | Эрсдэлийн түвшин | 24.7 | 24 | 24 | Төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг 18 сум 2 тосгон, аймгийн төрийн сан, нийт 21 нэгжид 20 асуулга бүхий эрсдэл үнэлэх хуудсаар үнэлэхэд эрсдэл 2021 онд 23.8 хувьтай буюу дунд, 2022 онд 23.1 хувьтай буюу дунд, 2023 онд 22.6 хувьтай буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бол 2024 онд 21 хувьтай буюу бага эрсдэлтэй үнэлэгдэж эрсдэлийн түвшин буурсан байна. 2025 онд Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Чандмань сум болон Гуулин, Баянтоорой тосгоны төрийн сангийн нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийлээ. Сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг гүйцэтгэхдээ үндсэн 22 үзүүлэлтийг тус бүр 1-5 хүртэлх баллаар дүгнэсэн бөгөөд илэрсэн зөрчил, алдаа дутагдлыг цаашид давтан гаргахгүй байх талаар зөвлөмж, хугацаатай үүрэг даалгавар өгч ажиллалаа. 2026 оны 01 сарын 30-ны дотор 2025 оны эрсдэлийн үнэлгээг Сангийн яаманд хүргүүлэн ажиллана. | 100 |
| 1.4 | Төсвийг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих, тайлагнах үе шат бүрт төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлнэ. | - | Төсвийн хэмнэлт бий болсон байна. | - | - | Нийт төсвийн 0.1 хувийн төсвийн хэмнэлт бий болгоно. | Орон нутгийн төсөвт нийтдээ 41420.2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс эхний 11 дүгээр сарын байдлаар 37821.6 сая төгрөг төсөвт төвлөрч сарын төлөвлөгөө өссөн дүнгээр 111.5 хувь, жилийн төлөвлөгөө 91.3 хувь, улсын төсөвт 4237.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 4647.4 сая төгрөг төвлөрүүлж жилийн төлөвлөгөө 109.7 хувийн биелэлтэй байна. Төсвийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэлийн 11 дүгээр сарын мэдээгээр төсвийн зарлага 97,622.3 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 78,838.3 сая төгрөгийн буюу 80.7 хувийн гүйцэтгэл гарч 19.3 хувийн хэмнэлттэй байна.<br>Улсын төсвийн санхүүгийн дэмжлэгээр 19,659.6 сая төгрөгийг хуваарийн дагуу бүрэн авч сум, байгууллагуудын дэмжлэгийг олгов. Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр 18303.7 сая төгрөгийн төлөвлөгөөтэйгөөс 18158.8 сая төгрөгийн санхүүжилт авч 99.2 хувийн гүйцэтгэлтэй байна. /12 сарын байдлаар/ | |
| 1.5 | Төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зардал хэмнэх, асуудлаар хэлэлцүүлэг, сургалт зохион байгуулах. | - | Төсвийн орлого нэмэгдэх, хэмнэлт бий болох. | - | - | Хэлэлцүү-лэг сургалт зохион байгуулна. | Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Шинэ сэргэлтийн бодлого”-ын төсвийн шинэчлэлийн хүрээнд аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар захирамжаар орон нутгийн төсвийн орлогын бааз суурийг нэмэгдүүлэх зорилго бүхий ажлын хэсэг байгуулан, тайлант онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй “Хан-Алтай ресурс” ХХК, “Алтайн хүдэр” ХХК-аас орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэн ажиллалаа | 90 |
| 1.6 | Төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, нэгж төсвийн үр өгөөжийг дээшлүүлэх, төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар төсөвт байгууллагын удирдлага хамт олны хүрээнд идэвхи санаачилга өрнүүлэх, аян | - | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажиллах | Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгж-үүлэн ажилласан | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Шүүх, Цагдаагийн газар, Төрийн аудитын газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Татварын хэлтэс, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын алба зэрэг хууль хяналтын байгууллагуудтай хамтарсан хэлэлцүүлэг зохион байгуулж, 8 бүлэг, 46 | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулан санхүүгийн зөрчил, төсвийн өр төлбөр үүсгэхгүй байхад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна | | | | | | заалт бүхий “Төсвийн ил тод байдлыг хангаж, сахилга хариуцлагыг нэмэгдүүлэх тухай” аймгийн Засаг даргын 2022 оны 01 албан даалгавар гаргасан. Уг албан даалгаврын хэрэгжилтийг энэ төсвийн жилд үргэлжлүүлэн тооцож байгаа бөгөөд 4 дүгээр улирлын байдлаар 91 хувийн хэрэгжилттэй байна. | |
| **2. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** | | | | | | | | |
| 2.1 | 2026 оны орон нутгийн төсвийн төслийг боловсруулан Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна. | - | ИТХ-аар батлуулсан байх | АИТХ-ын 2023-оны 71 дугаар тогтоолоор батлагдсан. | - | ИТХ-аар батлагдсан байна. | Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам болон Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу орон нутгийн төсвийн байгууллагуудын 2026 оны төсвийн төслийг 2025 оны 06 дугаар сарын 10-ны дотор хүлээн авсан. Ирүүлсэн төсвийн төслийг хянаж нэгтгэн Төсвийн тухай хуульд заасан хугацаанд орон нутгийн төсвийн орлогыг 26368.8 сая төгрөгөөр, урсгал зардлыг 57802.7 сая төгрөгөөр тус тус Сангийн яаманд хянуулсан. Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлж, орон нутгийн 2026 оны төсвийн төслийг 11-р сарын 25-ны өдрийн дотор боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж. Аймгийн ИТХ-аар 2025.12.03-ны өдөр хэлэлцүүлэн батлуулан ажиллаж байна. | 100 |
| 2.2 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлж аудит хийсэн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ. | 1,1 сая төгрөг | Тайланд хамрагдсан байгууллагын тоо | 247 нэгж байгууллага | 247 нэгж байгууллага | 247 нэгж байгууллага | Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсөвт байгууллагын 45, төсөл сангийн 58, төрийн сангийн нэгжийн 21, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 13, хяналтанд байгаа 15 нэгж, байгууллага болон орон нутгаас | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтмол зардлын болон төрийн үйлчилгээний зардлын санхүүжилт авсан байгууллагын 99 тайлан нийт 251 нэгжийн тайланг хамруулсан.<br>Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Төрийн аудитын байгууллагад хүргүүлж аудитлагдсан тайланг Сангийн яаманд хүргүүлсэн. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн санхүүгийн аудитаар *“Хязгаарлалттай”* дүгнэлт авсан. | |
| 2.3 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн яаманд хүргүүлнэ | - | Хуулийн хугацаанд хүргүүлэх. | 2023 оны 08 сарын 14-нд хүргүүлсэн. | - | 2024 оны 08-р сарын 15-ны дотор хүргүүлэх | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсөвт байгууллагын 44, төсөл сангийн 58, төрийн сангийн нэгжийн 21, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 13, хяналтанд байгаа 15 нэгж, байгууллага болон орон нутгаас тогтмол зардлын болон төрийн үйлчилгээний зардлын санхүүжилт авсан байгууллагын 99 тайлан нийт 250 нэгжийн тайланг хамруулан нэгтгэж нэгтгэсэн тайланг 8 дугаар сарын 12-нд Сангийн яаманд хүргүүлсэн. | 100 |
| 2.4 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны төсвийн гүйцэтгэлийг ИТХ-аар хэлэлцүүлнэ | - | ИТХ-аар батлуулсан байх. | ТЕЗ-ийн 2022 оны төсвийн гүйцэтгэлийг АИТХ-ын 2023 оны 75 дугаар тогтоолоор баталсан. | - | ИТХ-аар батлагдсан байна. | Аймгийн ИТХ-ын 2025 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 38 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн 2024 оны орлогын гүйцэтгэлийг 79677.7 сая төгрөгөөр, зарлагын гүйцэтгэлийг 76355.1 сая төгрөгөөр тус тус хэлэлцүүлэн батлуулсан. | 100 |
| 2.5 | Улсын болон орон нутгийн төсвийн байгууллагын төлбөр тооцооны гүйлгээг | - | Төрийн санд хийгдсэн гүйлгээний | 2023 онд 17982 ширхэг | - | - | Санхүүгийн анхан шатны баримт, батлагдсан төсөв, төсвийн хуваарьт үндэслэн 43 төсөвт байгууллагуудын 183 дансны 59662 ширхэг | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Сангийн сайд болон аймгийн Засаг даргын баталсан сар улиралын хуваарийн дагуу аймаг, сумдын төрийн сангийн дансаар дамжуулан цахим системээр гүйцэтгэнэ. | | тоо, мөнгөн дүн | төлбөрийн даалгавраар 94.8 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн | | | төлбөр тооцооны гүйлгээг Төрийн сангийн удирдлагын цахим системээр, нууцын зэрэгт хамаарах 4 байгууллагын 698ширхэг гүйлгээгээр 13.1тэрбум төгрөгийн төлбөр тооцооны гүйлгээг төрийн сангийн Freebalance системээр холбогдох эрх зүйн акт, анхан шатны баримтыг үндэслэн хийж гүйцэтгэн, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Мөн төсөвт байгууллагаас эрсдэлтэй гүйлгээ гарахаас сэргийлж 917 ширхэг гүйлгээг хууль, журам, зааврын дагуу хянан буцааж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | |
| 2.6 | Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг баримтаар болон цахимаар хэрэгжүүлэх | 1,2 сая төгрөг | Хамрагдсан сумын тоо, өдөр тутамын гүйлгээ | 17 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийсэн | 5 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх | 5 сумын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх | Засгийн газрын 2023 оны 12 сарын 13-ны өдрийн 444 дүгээр Тогтоолоор “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэн баталсан бөгөөд тус журмын 3.11.4-д заасны дагуу гарын үсгийн баталгааны маягтын иж бүрдэлд хяналт тавьж төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нараас баталгаажуулан авч эрхийн бүртгэлийн сан системд бүртгэх талаар сумдын төрийн сангийн нэгжүүдэд үүрэг өгч хэрэгжилтийг хангуулан ажилласан. Төрийн сангийн эрсдэлийн үнэлгээг 18 сум 2 тосгон, аймгийн төрийн сан нийт төрийн сангийн 21 нэгжид 20 асуулга бүхий эрсдэл үнэлэх хуудсаар үнэлэхэд эрсдэл 23.8 хувьтай буюу дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бөгөөд сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд өдөр тутмын дотоод хяналтыг цахимаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Төрийн сангийн 2024 оны дотоод хяналтын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлэх хугацаа болоогүй. | 100 |
| 2.7 | Аж ахуйн нэгж байгууллагуудын санхүүгийн тайланг И-Баланс цахимаар хүлээн авч баталгаажуулан нэгтгэлийг Сангийн яаманд | 0,2 сая төгрөг | Тайлан тушаалтын хувь | 84 хувь | 85 хувь | 85 хувь | Аймагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг шинэчлэгдсэн https://e-balance.mof.gov.mn/ цахим системээр 86 хувийн ирцтэйгээр хянан хүлээн авч баталгаажуулсан. 2025 оны | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргүүлнэ. | | | | | | эхний хагас жилийн тайланг э-баланс системээр хүлээн авч, хянан баталгаажуулахад илэрсэн бүртгэлийн алдааг залруулсан. Мөн алдаатай тайлагнасан 280 гаруй аж ахуйн нэгж байгууллагын тайланг засварлах заавар гарын авлагыг бэлтгэн байгууллага, сумдын төрийн сангийн мэргэжилтнүүдэд хүргэн тайланг засварлан хүлээн авч баталгаажуулсан. | |
| 2.8 | Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын 2024 оны тайланг нэгтгэн цахим системээр тайлагнана. | - | Тайлан, мэдээг хүргүүлсэн байх | Хугацаанд нь тайлагнасан. | - | Тайлан, мэдээг хүргүүлсэн байна | Ашигт малтмал газрын тосны хайгуул, олборлолт эрхэлдэг аж ахуйн нэгжээс 2023 онд орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хураамж, хандив тусламжийг тайлагнах ажлыг зохион байгуулж, 36 аж ахуйн нэгжийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн албан татвар, төлбөр, хураамж төрийн болон төрийн бус байгууллагат өгсөн хандив, тусламжийг ereporting.eitimongolia.mn цахим системд оруулан нийтэд мэдээлэн ажиллав. | 100 |
| 2.9 | Санхүүгийн зохицуулах хорооны чиг үүргийг орон нутагт хэрэгжүүлэх. | - | Тайлан, мэдээг хүргүүлсэн байх | Хагас, бүтэн жилийн тайланг хүргүүлсэн. | Тайлан мэдээг хүргүүлсэн байна. | Тайлан мэдээг хүргүүлсэн байна. | Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2021 оны 329 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт маягтын дагуу аймгийн зохицуулалттай байгууллагуудаас хагас жилийн тайлан, тоон мэдээллийг авч нэгтгэн 2025 оны 06 дугаар сарын 11-нд албаны мэйл хаягаар /www.office.com/ хүргүүлсэн. Тайлант онд иргэн З.Алтанцэцэгээс ирсэн хүсэлтийг судлан Аймгийн Засаг даргын 2025.03.07-ны А/102 дугаар захирамжаар мөнгөн зээлийн үйл ажиллагааг эрхлэх иргэнээр бүртгэж 31882250001 дугаар гэрчилгээг олгов. Жилийн эцсийн тайлан мэдээг авч нэгтгэж байна | 100 |
| 2.10 | Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй | - | Хяналт шалгалт хийсэн байх | 2023 онд 3 байгуулагад хяналт | 12 байгууллагад 1 удаа | 12 байгууллагад 1 удаа | Цагдаагийн байгууллагатай хаамтран аймагт үйл ажиллагаа явуулж байгаа ломбардны үйл ажиллагаанд хяналт хийж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж зөвлөмж, чиглэл өгч ажиллана. | | | хийсэн | шалгалт хийх | шалгалт хийх | зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулж байгаа газрыг түр зогсоож бүртгэл хүсэх ажиллахыг үүрэг болгов. | |
| 2.11 | АИТХ-с гарсан шийдвэр хэрэгжүүлэх, тогтоолуудын хэрэгжилтийг хангах чиглэлээр бодитой үр дүнтэй ажил зохион байгуулах | - | АИТХ тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг хангагдана | АИТХ тогтоол, шийдвэрийн хэрэгжилт-ийг хангаан ажилласан. | Шийдвэр-ийн биелэлтийг бүрэн хангана. | Шийдвэр-ийн биелэлтийг бүрэн хангана. | Говь-Алтай аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас орон нутгийн төсөв батлах, татварын болон татварын бус орлогын хувь хэмжээ, 2023 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай зэрэг хэлтсийн чиг үүрэгт хамааралтай гаргасан шийдвэрийг төсвийн жилд хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100 |
| 2.12 | Төрийн болон дотоод аудитын зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангаан ажиллах чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулах | - | Зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж ажиллана | Зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлж ажилласан. | - | Зөрчил буурсан байна: | Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсөвт байгууллагын 45, төсөл сангийн 58, төрийн сангийн нэгжийн 21, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 13, хяналтанд байгаа 15 нэгж, байгууллага болон орон нутгаас тогтмол зардлын болон төрийн үйлчилгээний зардлын санхүүжилт авсан байгууллагын 99 тайлан нийт 251 нэгжийн тайланг хамруулсан бөгөөд 60 нэгж, байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргуулж, 81 нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн үе шатны ажлыг хэсэгчлэн хийж бие даасан дүгнэлт гаргалгүйгээр түүвэрт хамруулсан. Санхүүгийн тайлангийн аудитаар 60 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж, 24 байгууллагад “өөрчлөлтгүй” , 33 байгууллагад “хязгаарлалттай”, 2 байгууллагад “сөрөг дүгнэлт өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, актын биелэлтийг заасан хугацаанд гарган Төрийн аудитын байгууллагад хүргүүлсэн. | 90 |
| 2.13 | Монгол Улсын 2024 оны | - | Орлогын | Улдсын | Улсын | Улсын | Орон нутгийн төсөвт нийтдээ 41420.2 сая | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | төсвийн тухай хуулиар батлагдсан улсын болон орон нутгийн төсвийн орлогыг цаг хугацаанд нь татварын болон татварын бус орлогын нэр төрлөөр нь бүрэн төвлөрүүлэх | | гүйцэтгэл /хувиар/ | төсвийн орлого хувь, орон нутгийн төсвийн орлого хувиар биелсэн. | болон орон нутгийн төсвийн орлогыг 100 хувь биелүүлнэ. | болон орон нутгийн төсвийн орлогыг 100 хувь биелүүлнэ. | төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс эхний 11 дүгээр сарын байдлаар 37821.6 сая төгрөг төсөвт төвлөрч сарын төлөвлөгөө өссөн дүнгээр 111.5 хувь, жилийн төлөвлөгөө 91.3 хувь, улсын төсөвт 4237.3 сая төгрөг төвлөрүүлэхээс 4647.4 сая төгрөг төвлөрүүлж жилийн төлөвлөгөө 109.7 хувийн биелэлтэй байна. | |
| Зорилт 3 **Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт** | | | | | | | | |
| 3.1 | Сумдын санхүүгийн алба, төрийн сангийн мэргэжилтэнгүүд, төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдод шинээр батлагдсан заавар журмаар танхим болон цахим хэлбэрээр сургалт зохион байгуулж ажлын үр дүнг сайжруулна | 2,4 | Нягтлан бодогч санхүүгийн ажилтанууд ын эрх зүйн мэдлэг сайжирна. | Сургалтад оролцсон хүний тоо 45 | Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөх шинэчлэгдсэн заавар журам хэрэгжинэ. | Төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нийтээр дагаж мөрдөх шинэчлэгдсэн заавар журам хэрэгжинэ. | Аймгийн санхүүгийн ажилтны зөвлөгөөнийг 2025 оны 11-р сарын 14-ний өдөр зохион байгуулсан бөгөөд зөвлөгөөний үеэр сумын санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнүүдэд шинээр гарсан журам, зааврын талаар танилцуулга хийн санхүүгийн тайлан гаргахад анхаарах зүйлсийн талаар арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. | 100 |
| 3.2 | Төрийн сангийн цахим шилжилтийг нэвтрүүлэх, сумдын санхүүгийн ажилтнуудыг тасралтгүй удирдлагаар хангаж заавар зөвлөгөөг тухай бүр өгч ажиллах. | 2,0 | 1256 дансыг эрхийн бүртгэлийн системд холбох тохиргоо хийсэн | 1256 дансыг эрхийн бүртгэлийн систем, портал системд холбоно. | Цахим төлбөрийн систем нэвтрүүлэх боломж бүрдэнэ. | Цахим төлбөрийн систем нэвтрүүлэх боломж бүрдэнэ. | Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан цахим шилжилтийн бодлого, зорилттой уялдуулан төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр төрийн сангийн цахим шилжилтийг үе шаттай нэвтрүүлсэн бөгөөд 176 төсөвт байгууллагын 1256 дансыг эрхийн бүртгэлийн системд холбож эрхийн тохиргоог бүрэн хийж төрийн сангийн цахим шилжилтийг бүрэн нэвтрүүлсэн. Төрийн сангийн цахим төлбөр тооцооны Портал системийг ашиглах талаар заавар зөвлөгөөг аймаг, сумдын төсөвт байгууллагуудын дарга, нягтлан бодогч нарт тухай бүр өгөн хяналт тавьж ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3 | Хөрөнгийн зах зээлийн талаар иргэдэд мэдлэг олгоход чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах, | - | Сургалт зохион байгуулна. | 1 | - | 1 | Санхүүгийн зохицуулах хорооноос зохион байгуулсан Хөрөнгийн зах зээл ба 1072 хувьцаа сургалтыг 2024 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн төрийн албан хаагчдад хийж нийт 350 албан хаагчдыг хамруулллаа. | 100 |

*Төлөвлөгөөг үнэлсэн:* **Төсвийн шууд захирагч**

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА ............................ /Ш.ЭРДЭНЭБАТ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.09 *(огноо)*

*Тайлагнасан:* **Нэгжийн дарга**

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА Л. Хаш-Эрдэнэ ............................ /Л.ХАШ-ЭРДЭНЭ/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

2025.12.03 ............................ *(огноо)*